

## ЭРДЭНЭ ҮРЛИЙН ЭМНЭЛ ЗҮЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

Ү фен жяо<sup>1</sup>, Болор<sup>1</sup>, Ван хуй<sup>1</sup>, Ван шү лан<sup>1</sup>

<sup>1</sup>Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн Монгол эм эмнэлгийн дээд сургууль  
(NMDSS1837)

Email-1324591309@qq.com

## REVIEW OF EERDUN-WURILE CLINICAL RESEARCH

Wu Feng Jiao<sup>1</sup>, Bao Lu Er<sup>2</sup>, Wang Hui<sup>3</sup>, Wang Xiu Lan<sup>4</sup>

<sup>1</sup>College of Mongolian Medicine and Pharmacology, Inner Mongolia University for the Nationalities  
(NMDSS1837)

Email-1324591309@qq.com

### Abstract

**Objective:** To summarize the clinical application of Zhenbao pills (Eerdun-Wurile) in recent years, so as to clarify its clinical efficiency and provide an effective basis for future research.

**Methods:** The clinical application of Zhenbao pills ( Eerdun-Wurile ) was classified and summarized by consulting the relevant literature.

**Results:** Mongolian medicine Eerdun-Wurile consists of many active ingredients such as *Sandalwood Padauk*, pearl, *Myristica fragrans*, *Calculus bovis*, Bufallo horn concentrated powder, *Gardenia jasminoides Ellis*, *Glycyrrhiza uralensis Fisch*, *Euphorbia humifusa*, *Catsia tora Linn*, *Chingma Abutilon Seed*, Resina Liquidambaris, *Carthamus tinctorius L*, *Eugenia caryophyllata Thunb*, *Cardamom amomum*, *Semen Nigellae*, *Cuminum cyminum L*, *Piper longum Linn*, *Lygodium japonicum*, crab, medicine terminalia fruit, *MeLia toosendan Sieb.et Zucc*, musk, white sandalwood, *Cinnamomum cassia Presl*, *Aucklandia lappa Decne*, *Inula helenium L*, *Amomum tsao-ko Crevost et Lemaire* etc. Mongolian medicine Eerdun-Wurile used for treat cardiovascular and cerebrovascular diseases, cerebral infarction, cerebral infarction and ischemic stroke, rheumatic heart disease, coronary heart disease, angina pectoris, rheumatism, kind rheumatism, cervical spondylosis, arthritis, insomnia, high blood pressure, epilepsy, skin diseases, diabetes, eye diseases.

**Conclusion:** Mongolian Medicine Eerdun-Wurile has remarkable curative effect on cardiovascular and cerebrovascular diseases, brain infarction, cerebral infarction, ischemic stroke, diabetic diseases, rheumatism, bone diseases and so on. In this paper, the curative effect of this drug was summarized to provide reference for its clinical application.

**Keywords:** Mongolian medicine; Eerdun-Wurile; Clinical research progress

### Удиртгал:

Монгол эм Эрдэнэ үрлийн өөр нэр нь “Сампилноров” бөгөөд Увидсын далайд эрдэнийн үрлийн найрлагын бүрэлдэхүүн нь улаан зандан 40 гр, номхотгосон сувд 10 гр, задь 6 гр, гиван, усан үхрийн эврийн агшаамал нунтаг, жүр үр тус бүр 5 гр, чихэр өвс, малгайн залаа өвс, химийн үр, талгадорж, цагаан гүгэл тус бүр 4 гр, гүргэм, голт бор, сүгмэл, хар сайра, цагаан сайра, библин, алтан элс, наймаалж,

ар үр, бар үр тус бүр 3.5 гр, заар, цагаан зандан, хар агар тус бүр 3 гр, гавирын хальс 2.5 гр, рүда, мана тус бүр 2 гр, хулсан жуган, цагаан гагол тус бүр 1 гр байх ба эдгээрийг шар буурцгийн хиртэй үрэлдэж шунхаар гадарлан хэрэглэнэ. Цагаан судлын гэмтлийг арилгах, хуучирсан халууныг арилгах, шар усыг хатаах чадалтай. Голдуу засах нь хар, цагаан судлын өвчин, саа өвчин, тулай, хэрх, өмөн, шар усан өвчин, бөөрний судал доргиж бэртсэн,

бөөрний халуун, судас шөрмөс таталдах, халуун хуучирч судалд сарнисан, үе гишүү тахирдахад хэрэглэнэ. Тус эм нь олон талын үйлдэлтэйгээс гадна уламжлалт эмчилгээнд зонхилон хэрэглэх эм болжээ.

### **Судалгааны зорилго:**

Сүүлийн жилүүд дэх Эрдэнэ үрлийн эмчилгээний хэрэглэлийн тухай судалгааг хураангуйлан, түүний хэрэглээг сайтар тодруулж, хойшдын туршилт судалгаа ба эмчилгээний судалгааны ажилд зохих хэмжээний сурвалж бичгийн иш баримт хангахыг зорив.

### **Судалгааны арга:**

Эрдэнэ үрлийн эм зүйн үйлдлийн судалгаа болон жор найрлагын судалгааны байдлыг эртний сурвалж бичиг, CNKI өгөгдлийн сан дах эрдэм шинжилгээний өгүүллүүд болон сурах бичиг зэргээс эмхэтгэж, эрдэнэ үрлийн эмчилгээн дэх хэрэглээг хураангуйлав.

### **Судалгааны үр дүн:**

Монгол эм эрдэнэ үрэл нь тархи цусан судлын өвчин, хэрх өвчин, ясны өвчин, мэдрэлийн системийн өвчин зэрэгт нэлээдгүй эмчилгээний ач тустай.

#### **1. Тархины судасны бөглөрөл**

Хан шүү лан, Сарантуяа тархины судасны бөглөрөх өвчтэй 120 өвчтнийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар харьцуулах бүлэг болон эмнэн засах бүлэг гэж хоёр бүлэгт хувааж, бүлэг тус бүр 60 өвчтөн хуваасан байна. Харьцуулах бүлгийн өвчтөнд энгийн европ эм холимог найрлага улаан үндсийн тарилгын шингэн, нимодипин, аспирин, симвастатин, троксерутин зэргийг өгчээ. Эмнэн засах бүлэгт өглөө: Эрдэнэ үрэл 15 үрэл, үдэд: марчэн-13 тан 3 гр, орой: зачүн-13-ийн үрэл уулгасан ба хоёр бүлгийг харьцуулсны дараа Монгол эм Эрдэнэ үрлээр тархины судасны бөглөрөх өвчнийг эмнэн зассан нь илт сайн байна<sup>1,2</sup>.

Эд тив лүн тархины судасны бөглөрөх өвчтэй 65 өвчтнийг сонгон авч, эмнэн засах бүлэг 33 өвчтөн, харьцуулах бүлэг 32 өвчтөн гэж хоёр бүлэгт хуваажээ. Харьцуулах бүлэгт европ эм гингко навчны шингэн, озагрел хөлдүү нунтгаар голлож, үүний хамт цусны даралтыг тохируулах, гавлын даралтыг бууруулах, халдварлахаас сэргийлэх зэрэг зорилгоор эмнэн засжээ. Эмнэн засах бүлэгт харьцуулах бүлгийн эмийг хэрэглэхийн хамт Монгол эм Эрдэнэ үрлээр голлож, эрт орой тус бүр 15 үрэл, “бадган” арвидаж байвал тунгалаг-5, “шар” арвидаж байвал гурван үрийн танг өглөө орой усаар буцалган, “хий” арвидаж байвал агар-35 -ыг оройн цагаар тус тус хөл эм болгон уулгасан ба идэш муудсан байвал чихэр өвс-6-г өглөө усаар буцалгаж, шингээлт муудсан байвал шижид-6-г нэмж тус тус уулгасан байна. Хоёр бүлгийг харьцуулсны дараа Монгол эм Эрдэнэ үрлийг европ эмтэй хавсаргаж тархины судасны бөглөрөх өвчнийг зассан эмчилгээний дүн нь илт сайн байжээ<sup>3</sup>.

Хай пин тархины судасны бөглөрөх өвчтэй 70 өвчтөнийг авч, санамсаргүй түүвэрлэлтийн аргаар харьцуулах бүлэг болон ажиглах бүлэг гэж хоёр бүлэгт хувааж, харьцуулах бүлгийг европ эмнэлгийн аргаар эмнэн засаж, ажиглах бүлгийг европ эмнэлгийн аргаар эмнэн зассан суурь дээр өглөөний хоолны дараа Монгол эм Эрдэнэ үрэл 15 үрэл, оройн хоолны дараа Монгол эм зачүн-13 9 үрэл, үргэлжлүүлэн 14 хоног эмнэн засчээ. Хоёр бүлгийг харьцуулсны дараа Монгол европ эмнэлгээр эмнэн засах нь тархины судасны бөглөрөх өвчинд илүү үр дүнтэй байсан байна<sup>4</sup>.

#### **2. Тархины шигдээс**

Даяан ли чин 238 тархины шигдээстэй өвчтнийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар харьцуулах бүлэг болон эмнэн засах бүлэг гэж хоёр бүлэгт хувааж, харьцуулах бүлэг нь цусны даралт бууруулах, цусан дах сахарын хэмжээг

бууруулах, гавлын дотоод даралтыг бууруулах, мэдрэлийг хамгаалах, цусны судлыг өргөтгөх, цусны ялтсын бөөгнөрөхийг эсэргүүцэх зэрэг эмүүдийг хэрэглэжээ. Эмнэн засах бүлэгт харьцуулах бүлгийн эмнэн засах суурь дээр Монгол эм Эрдэнэ үрлийг нэмж хэрэглэж, нас, биеийн хүнд, өвчний байдал зэргийг нь үндэслэж удаа бүр 11-15 үрэл өглөөний хоолны дараа буцалсан усаар даруулан уулгажээ. Хоёр бүлгийг харьцуулсны дараа Монгол эм Эрдэнэ үрлээр тархины шигдээсийг эмнэн засах нь илэрхий сайн байсан ба Эрдэнэ үрэл нь цусны судлын бичил эргэлтийг сайжруулах, тархины цусан хамгамжийг нэмэгдүүлэх зэрэг эм зүйн үйлдлийг улам нэг алхам нотолжээ<sup>5</sup>.

### 3. Цусан хангамж дутагдах харвалт

Хоо юй үн цусан хангамж дутагдах харвалттай 120 өвчтнийг авч, санамсаргүй түүвэрлэлтийн аргаар харьцуулах бүлэг болон болон эмнэн засах бүлэг гэж хоёр бүлэгт хувааж, бүлэг тус бүр 60 өвчтөн хуваав. Харьцуулах бүлэгт гингко навчны хавтгай эм (ginkgo biloba tablet) 2 шахмал, өдөр бүр гурван удаа хоолны дараа уулгасан бөгөөд эмнэн засах бүлэгт Эрдэнэ үрэл, өдөр бүр нэг удаа, оройн хоолны дараа буцалсан бүлээн усаар уулгаж, хоёр бүлэгт бүр аспирин өдөрт нэг удаа, өглөөний хоолны дараа нэг ширхэгийг уулгаж 28 өдөр эмнэн засжээ. Хоёр бүлгийг харьцуулсны дараа Эрдэнэ үрэл нь цусан хангамж дутагдах харвалттай өвчтөний мэдрэлийн чадал доройтсоныг сайжруулж, өвчтөний зэрэмдэг хэмжээг бууруулж, өвчтөний бие даах чадвар нь дээшилжээ<sup>6</sup>.

### 4. Тархинд цус харвах

Иен яан 60 тархинд цус харвах өвчтнийг авч, харьцуулах бүлэг болон эмнэн засах бүлэг гэж хоёр бүлэгт хувааж, бүлэг тус бүрт 30 өвчтөн хуваажээ. Харьцуулах бүлэгт энгийн эмнэн засах аргаар өвчтөний бодитой байдалтай уялдуулж, мэдрэлийн шим тэжээлт

эм, цус зогсоох эм болон усгүйжүүлэх эмээр эмнэн зассан ба эмнэн засах бүлэгт энгийн эмнэн засах суурь дээр Монгол эм Эрдэнэ үрлийг өдөр бүр хоёр удаа, удаа бүр 2-3 гр уулгаж 14 хоног эмнэн зассан байна. Хоёр бүлгийг харьцуулсны дараа Монгол эм Эрдэнэ үрлээр эмнэн зассан нь илт сайн байж, өвчтөний биеийн байдал сайжирчээ<sup>7</sup>.

### 5. Чихрийн шижин өвчин

Урантуяа, Бай үн зэрэг 80 чихрийн шижинтэй өвчтнийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар харьцуулах бүлэг болон ажиглах бүлэг гэж хоёр бүлэгт хувааж, бүлэг бүрт нь 40 өвчтөн хуваажээ. Харьцуулах бүлэгт европ эм уулгаж, ажиглах бүлэгт харьцуулах бүлгийн эмнэн засах суурь дээр Монгол эм Эрдэнэ үрэл өгөв. Хоёр бүлгийг харьцуулсны дараа Монгол эм Эрдэнэ үрэл болон европ эм метил кобальт аминаар чихрийн шижин өвчнийг эмнэн зассан нь илт сайн байна<sup>8</sup>.

Ли вин шинчихрийн шижин өвчтэй 40 өвчтөнг сонгон авч, Монгол европ эмээр эмнэн засжээ. Нүүр талын шархлаа, халдварлахгүй өвчтөнд сахар бууруулах эмээр цусан дах сахарын хэмжээг бууруулах зорилгоор хэрэглэсэн. Шархлаа нь хүнд мөртөө халдварлах өвчтөнд сахар бууруулах эмээ зогсоож, инсулин тарьж цусны сахарыг багасгасан бөгөөд үүний хамт Гүргэм-13, Эрдэнэ үрэл ууж мөн левофлоксацинийг хэрэглэсэн. Судалгааны үр дүнд Монгол европ эмийг хавсаргаж эмнэн зассан нь илүү сайн үр дүнтэй байжээ [9].

И вен мин зэрэг 120 DPN (чихрийн шижин) оноштой өвчтөн сонгон авч, санамсаргүй түүвэрлэлтийн аргаар харьцуулах бүлэг болон эмнэн засах бүлэг гэж хоёр бүлэгт хувааж, бүлэг тус бүрт нь 60 өвчтөн хуваажээ. Үндсэн засалд идээ ундааг хязгаарлах, хөдөлгөөн хийх, эмт бодисоор цусан дах сахарыг бууруулах хийгээд өвчинд нь тохируулж эмнэн

засах зэрэг багтжээ. Эмнэн засах бүлэгт Монгол эм Эрдэнэ үрлийг өдөр бүр хоёр удаа, удаа бүр 3 гр, харьцуулах бүлэгт хүхэрт октан хүчлийн хэмжээг өдөр бүр нэг удаа, удаа бүр 0.6 гр хэмжээгээр өгсөн байна. Хоёр бүлгийн эмнэн засах хугацаа нь 24 долоо хоног байсан ба хоёр бүлгийг харьцуулсны дараа Монгол эм Эрдэнэ үрэл нь DPN өвчтөний биеийн байдлыг илт сайжруулжээ<sup>10</sup>.

### 6. Зүрхний бах

Жен ван бин зэрэг 60 зүрхний бах оноштой өвчтөн сонгон авч, санамсаргүй түүвэрлэлтийн аргаар харьцуулах бүлэг болон эмнэн засах бүлэг гэж хоёр бүлэгт хувааж, бүлэг тус бүрт 30 өвчтөн хуваажээ. Эмнэн засах бүлэгт Эрдэнэ үрлийг өдөр бүр хоёр удаа өглөө, үдэд тус бүр 13-15 үрэл, оройдоо зачүн -13-ыг 5-9 үрэл уулгажээ. Харьцуулах бүлэгт улаан үндэсний эмийг өдөр бүр 3 удаа, удаа бүр 3 ширхэгийг ууж, үргэлжлүүлэн 15 өдөр уусан байна. Хоёр бүлгийг харьцуулсны дараа Эрдэнэ үрэл болон зачүн-13 -ийг хэрэглэж эмнэн засах нь зүрхний бахын өвдөлтөнд илэрхий сайн үр нөлөө үзүүлсэн байна<sup>11</sup>.

### 7. Хэрх

Бай буу хаа зэрэг Монгол эм Эрдэнэ үрлийн дээр натрийн гиалуронат тарилгын шингэнийг бэлчирт тарьж үе гишүүний хэрх өвчнийг эмнэн засах судалгаа хийсэн байна. Натрийн гиалуронат тарилгын шингэнийг бэлчирт тарьж дээр нь Эрдэнэ үрэл уусан эмчилгээний үр дүн нь илт сайн байжээ<sup>12</sup>.

Номин зэрэг Монгол эм эмт угаал болон Монгол эмийг хавсаргаж хэрэх үетэл, үе гишүүний хэрх өвчинтэй 87 өвчтөнд эмнэн засал хийж ажигласан байна. Эмт угаалын бүрэлдэхүүнд голдуу таван рашаан амтат шар тэрэлж, балгана, арцын өргөс, зээргэнэ, цагаан шаваг зэрэг агуулагдаж байжээ. Сонгож хэрэглэсэн Монгол эм нь Эрдэнэ үрэл, гагол-4 тан зэрэг байсан ба эмнэн зассан үр дүн нь илт сайн байсан байна<sup>13</sup>.

### 8. Хүзүүний үений өвчин

Фан юй лан 100 хүзүүний үений өвчинтэй өвчтнийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар харьцуулах бүлэг болон эмнэн засах бүлэг гэж хоёр бүлэгт хувааж, бүлэг бүр нь 50 өвчтөнтэй байв. Харьцуулах бүлгийг татлага хийхээр дамжин эмнэн засаж, өдөр бүр 2 удаа, удаа бүр 30 минут үргэлжлэн татуулсан ба татах хүч нь 7-10 кг. Эмнэн засах бүлэгт харьцуулах бүлгийн эмнэн засах суурь дээр криптоксин мөхлөг эм ууж дээр нь Монгол эм Эрдэнэ үрэл өдөрт 2 удаа, удаа бүр 15 үрэл хоолны дараа буцалсан бүлээн усаар уулгаж үргэлжлэн 3 долоо хоног эмнэн засчээ. Монгол эм Эрдэнэ үрлийн дээр хүзүүний татлагаар эмнэн зассан нь үр дүн сайтай байжээ<sup>14</sup>.

### 9. Саа өвчин

Навч 48 саа өвчинтэй өвчтнийг эмнэн засжээ. Эмнэн зассан арга нь Монгол эм Эрдэнэ үрлийг өдөр бүр 1-2 удаа, удаа бүр 15 үрлийг хоолны дараа уулгаж, орой унтахаас өмнө зачүн-13-ийг 11 үрэл, эрт хоолноос өмнө гарши-15 үрэл уулгасан. Эмнэн зассаны дараах үр дүн нь илт сайжирсан байна. Лиу эн гө<sup>[16]</sup> саа өвчтэй 86 өвчтөнг, санамсаргүй түүвэрлэлтийн аргаар эрүүл харьцуулах бүлэг болон эмнэн засах бүлэг гэж хоёр бүлэгт хувааж, бүлэг бүр нь 43 өвчтөнтэй байв. Эмнэн засах бүлэгт Монгол эм Эрдэнэ үрлээр гол болгон эмнэн зассан ба харьцуулах бүлэгт европ эмийн эмнэн засах үндсэн засах аргаар эмнэн засжээ. Судалгааны үр дүнд эмнэн засах бүлгийн өвчтнүүдийн биеийн байдал илүү сайжирсан байна<sup>15</sup>.

### 10. Хэрх чанартай зүрхий өвчин

Буу мин шье зэрэг 85 хэрх чанартай зүрхний өвчинтэй өвчтнийг эмнэн засжээ. Эмнэн засах арга нь өглөө Эрдэнэ үрэл 15 үрэл, үдэд сурчинноров-13 үрэл, орой гарди-15 13 үрэл, агар-35 3 гр ууна. Хий арвидсан тохиолдолд агар-8, задь-5, сурчин-11, бадган

арвидсан тохиолдолд тунгалаг-5, шар арвидсан тохиолдолд агар-18, зандан-3 тан, шар ус арвидвал дээр нь сэндэн-4 тан зэргийг 15 өдрийн турш тус тус нэмж уулгасан. Судалгааны үр дүнд илэрхий сайжирсан байна<sup>17</sup>.

Чин шяо хэрх чанартай зүрхний өвчинтэй 84 өвчтөнг сонгон авч, санамсаргүй түүвэрлэлтийн аргаар харьцуулах бүлэг 41 өвчтөн, эмнэн засах бүлэг 43 өвчтөн гэж хоёр бүлэгт хуваажээ. Эмнэн засах бүлэгт Монгол эмээр эмнэн засах аргыг хэрэглэж өглөөний хоолны дараа Эрдэнэ үрэл 15 үрэл, зандан-3-ийн танг 3 гр хэмжээгээр буцалган уулгасан ба үдийн хоолны дараа амин Эрдэнэ 13 үрэл, зүрхэн агар-8 танг 3 гр-ыг буцалсан усаар, оройн хоолны дараа шош-7 -ийг 13 үрэл буцалсан бүлээн усаар, орой унтахаас өмнө нэг цаг хөх гарьд-15 17 үрэл, сэндэн-4 тан 3 гр-ыг буцалгаж тус тус уулгасан. Халуурсны дараа эрхэм-8 тан 3 гр-ыг буцалсан усаар ууна, усан хавдартай үест ус-7 хэрэглэж, шингээлт доройдсон байвал тунгалаг-5, рүда-6 хэрэглүүлжээ. Харьцуулах бүлгийг Хятад эмээр эмнэн засах аргыг хэрэглэсэн бөгөөд голдуу зүрхний тамирыг сайжруулах, шээлгэх, судлын сүвийг нээх эмээр эмнэн зассан байна. Хоёр бүлгийг үргэлжлүүлэн 30 өдөр эмнэн зассан үр дүнг харьцуулахад Монгол эмээр эмнэн зассан эмчилгээний үр дүн нь илт сайн байсан байна<sup>18</sup>.

### 11. Нүдний өвчин

Ван вей нүдний өвчтэй 86 өвчтөнг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар харьцуулах бүлэг 32 өвчтөн, эмнэн засах бүлэг 54 өвчтөн гэж хоёр бүлэгт хуваажээ. Эмнэн засах бүлэгт Монгол эм Эрдэнэ үрэл 15-20 үрлээр өдөр бүр 1-2 удаа уулгаж харьцуулах бүлэгт европ эмийн үндсэн заслаар эмнэн засаж, үргэлжлүүлэн гурван сар эмнэн зассан байна. Хоёр бүлгийг харьцуулсны дараа Монгол эм Эрдэнэ үрлээр эмнэн зассан үр дүн нь илэрхий сайн байна<sup>19</sup>.

### 12. Эпилепси

Цогбадрах эпилепси өвчтэй 30 өвчтөнд засал хийжээ. Эмнэн засах арга нь өглөөний хоолноос өмнө нэг цаг өвчтөний хоргослосон байдлыг үзжээ. Хэрвээ хоргослож байвал гарши 3 гр, хоргослоогүй бол алтан агар-5 15 үрэл буцалсан усаар уулгасан байна. Үдийн хоолны дараа нэг цаг Эрдэнэ үрэл 15 үрэл, орой унтахаас өмнө гарьд-13 7-9 үрэл агар-35-аар даруулан уулгасан. Эм уух хугацаанд өвчтөн идээ ундааны талаар амархан шингээх идээ идэж, сэтгэл санаагаа тайван байлгаж, уурлах, ядрах зэргээс зайлсхийх шаардлагатай болохыг зөвлөсөн байна. Эмнэн зассаны дараах үр дүн нь өвчтөний байдал илт сайжирсан байна<sup>20</sup>.

Бай жье ү зэрэг Монгол эм Эрдэнэ үрлийг өөр Монгол эмтэй хавсаргаж 30 унадаг өвчтэй өвчтөнийг нэг сар эмнэн засжээ. Эмнэн зассан үр дүн нь илэрхий сайн болсон байна<sup>21</sup>.

### 13. Арьсны өвчин

Оюунтана арьсны өвчтэй 60 өвчтөнийг уламжлалт Монгол эмнэлгийн аргаар эмнэн засжээ. Өглөөний хоолны дараа Эрдэнэ үрэл 15 үрэл, үдийн хоолны дараа гүргэм-13 15 үрэл, оройн хоолны дараа очир найрлага 9 үрлийг гурван үрийн тан 5 грамаар буцалган даруулж ууна. Эмнэн зассан үр дүн нь илт сайн байсан байна<sup>22</sup>.

### 14. Хэт ясжилт

Оргил хэт ясжилттай 54 өвчтөнийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар харьцуулах бүлэг болон эмнэн засах бүлэгт хуваажээ. Харьцуулах бүлэгт Монгол эмнэлгийн зүү төөнөөр, эмнэн засах бүлэгт Монгол эмнэлгийн зүү төөнө засал дээр Монгол эм Эрдэнэ үрлээр эмнэн зассан байна. Хоёр бүлгийг харьцуулахад Монгол эм Эрдэнэ үрэл нэмж зассан үр дүн нь сайтай байжээ<sup>23</sup>.

### 15. Цусны даралт ихсэх өвчин

Хи вин фен 100 цусны даралт ихсэх өвчинтэй өвчтөнийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар харьцуулах бүлэг болон эмнэн засах бүлэг гэж хоёр бүлэгт хувааж, бүлэг тус бүрт нь 50 өвчтөн хуваажээ. Эмнэн засах бүлгийг Монгол эм Эрдэнэ үрлээр гол болгож эмнэн засаж, харьцуулах бүлгийг европ эмнэлгийн үндсэн заслаар эмнэн зассан ба үр дүнг харьцуулахад цусны даралтыг илэрхий сайн бууруулсан байна<sup>24</sup>.

### 16. Нойргүйдэл

Буу гэрэл 79 нойргүйдэлтэй өвчтөнийг эмнэн засчээ. Эмнэн засахдаа орой унтахаас өмнө Монгол эм Эрдэнэ үрэл 15 үрэл, сүгмэл-3 тангаар хөл эм болгож уулгасан байна. Гурван долоо хоног эмнэн зассаны дараах үр дүн нь сайн байсан байна<sup>25</sup>.

### 17. Атеросклероз

Тунгалаг атеросклероз өвчинтэй 100 өвчтөнийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар харьцуулах бүлэг болон эмнэн засах бүлэг гэж хоёр бүлэгт хувааж, бүлэг бүрт нь 50 өвчтөнтэй байсан бөгөөд харьцуулах бүлэгт аспирин, эмнэн засах бүлэгт Монгол эм Эрдэнэ үрэл өгчээ. Хоёр бүлгийг харьцуулсанд Монгол эм Эрдэнэ үрлээр эмнэн зассан үр дүн нь илт сайн байжээ<sup>26</sup>.

### 18. Үе гишүүний үрэвсэл

Ние чяо жен 84 өвдөгний үеийн үрэвсэлтэй өвчтөнийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар эмнэн засах бүлэг болон харьцуулах бүлэг гэж хоёр бүлэгт хуваан судалгаа хийсэн байна. Эмнэн засах бүлэгт Монгол эм Эрдэнэ үрэл болон физик эмчилгээг хавсруулан эмнэн зассан ба харьцуулах бүлэгт Монгол эм Эрдэнэ үрлээр эмнэн засжээ. Хоёр бүлгийг харьцуулсны дараа эмнэн засах бүлгийн эмчилгээний үр дүн илэрхий сайн байсан байна<sup>27</sup>.

### Дүгнэлт:

Монгол эм Эрдэнэ үрлийн эмчилгээн дэх хэрэглэлийн сурвалж бичгийн мэдээлэл нь маш олон байна. Хураангуйллаас үзэхэд Монгол эм Эрдэнэ үрэл нь тархины судас бөглөрөх, тархины шигдээс, цусан хангамж дутагдах харвалт, тархинд цус харвах өвчин, чихрийн шижин өвчин, зүрхний бах, үе гишүүний хэрх үрэвсэл, хүзүүний үений өвчин, саа өвчин, хэрх чанартай зүрхний өвчин, нүдний өвчин, унадаг өвчин, арьсны өвчин, хэт ясжилт, цусны даралт ихсэх өвчин, нойргүйдэл, үе гишүүний өвчин зэрэгт илэрхий сайн үйлдэл үзүүлдэг, онцгойлон зарим өвчнийг Монгол европ эмнэлгээр эмнэн засах нь ганц европ эмнэлгээр эмнэн зассанаас сайн байна. Тус эм нь олон талын үйлдэлтэйгээс Монгол эм Эрдэнэ үрэл нь эмчилгээний хэрэглэлд зонхилон хэрэглэх эм болжээ. Дээрх Эрдэнэ үрлийн эмчилгээн дэх хэрэглэлийн судалгаанаас Эрдэнэ үрлийн чадал ба голдуу засахыг улам нэг алхам нотолж, Эрдэнэ үрлийн цаашид гүнзгийрүүлэн судлах судалгаанд суурь тавьсан байна.

### Номзүй:

1. 韩秀兰. 蒙药额日顿·乌日勒防治脑梗塞的疗效[J]. World Latest Medicine Information (Electronic Version), 2018, 18(79):196-197.
2. 萨仁图雅. 蒙药额日顿乌日勒治疗脑梗塞的临床研究[J]. 世界最新医学信息文摘, 2017, 17(73):17-19.
3. 何铁龙. 蒙药珍宝丸治疗急性脑梗塞的临床观察 [J]. 中国民族医药杂志, 2014, 20(1):10-10.
4. 海 萍. 蒙西医结合治疗脑梗塞的临床效果观察 [J]. 中国民族医药杂志, 2017, 9(9):45-46.
5. 田利清. 额日敦 — 乌日勒治疗脑梗死 132 例临床疗效观察 [J]. 中国民族医药杂志, 2011, 17( 8) : 10-10.
6. 胡玉荣, 斯钦其木格, 等. 蒙药额尔敦乌日勒联合西药治疗缺血性脑卒中恢复期临床观察 [J]. 中国民族民间医药, 2017, 26(

- 23) : 116 — 119.
7. 姜岩, 用蒙药珍宝丸治疗脑出血的效果研究 [J]. 临床医药文献杂志, 2018, 5(5):145-145.
8. 乌仁图雅, 白云. 珍宝丸治疗糖尿病末梢神经炎的临床观察 [J]. 中国民族医药杂志, 2014, 4(4):14-15.
9. 刘金山, 艾丽根等. 蒙西医结合治疗糖尿病病足 40例 [J]. 中国民族医药杂志, 2008, 14(3):26-27.
10. 易文明, 张芳芳等. 蒙药珍宝丸治疗糖尿病周围神经病变痰瘀互阻证 54 例临床观察 [J]. 中医杂志, 2019, 1(1):42-46.
11. 郑万斌, 宋凯丽, 葛久欣, 等. 珍宝丸与扎冲十三味丸治疗冠心病心绞痛的疗效观察 [J]. 心血管康医学杂志, 2003, 12(2):179-180.
12. 白宝华, 李季珍. 蒙药珍宝丸加穴位注射施沛特 — (玻璃酸钠注射液) 治疗风湿性类风湿性关节炎的体 [J]. 中国民族民间医药, 2008, 17(8):65.
13. 诺敏, 蒙药药浴结合内服蒙药治疗类风湿性关节炎 87例疗效观察 [J]. 中国民族医药杂志, 2017, 23(1):18-19.
14. 房玉良, 蒙药“额日敦乌日勒”配合颈椎牵引治疗颈椎病临床观察 [J]. 中国民族民间医药, 2012, 21(12):12.
15. 娜布琪, 蒙西医治疗 48 例萨病临床报告 [J]. 中国民族医药杂志, 2008, 14(11):88.
16. 刘恩和, 蒙药额日顿 — 乌日勒治疗萨病(中风) 43 例临床疗效观察 [J]. 中国民族民间医药, 2014, 23(23):2-5.
17. 包明霞, 图木存花等, 蒙药治疗护理风湿性心脏病疗效观察 [J]. 中国民族医药杂志, 2018, 12(12):78-79.
18. 青晓, 蒙药治疗风湿性心脏病疗效观察 [J]. 中国民族医药杂志, 2016, 4(4):16-17.
19. 王伟, 珍宝丸治疗复视 54 例 [J]. 中国中医药科技, 2013, 20(6):681.
20. 朝格巴达日呼, 乌力吉特古斯等, 蒙医治疗 30 例癫痫病临床观察 [J]. 中国民族医药杂志, 2014, 5(5):5-6.
21. 白洁茹, 包散丹, 祁文慧, 等. 蒙药治疗 30 例癫痫的临床体会 — 附 30 例脑电图检测分析 [J]. 中国民族医药杂志, 2000, 6(增刊):34.
22. 乌云塔娜, 蒙药治疗淤滞性皮炎 60 例体会 [J]. 中国民族民间医药, 2008, 17(1):48.
23. ]敖日格乐, 蒙医温针加额尔敦乌日乐治疗膝关节骨质增生的效果观察 [J]. 中国民族医药杂志, 2017, 23(09):26-27.
24. 霍金凤, 高血压病患者的蒙西医结合护理体会 [J]. 世界最新医学信息文摘, 2017, 17(47):176-177.
25. 包格日勒, 元登, 等. 蒙药治疗白脉型失眠 79 例 [J]. 中国民族医药杂志, 2015, 21(11):19.
26. 通拉嘎, 蒙药额尔敦乌日勒治疗动脉硬化的观察 [J]. 世界最新医学信息文摘, 2018, 18(23):163-164.
27. 聂巧珍, 蒙药配合超短波、中频电治疗膝关节骨性关节炎 84 例观察 [J]. 疾病监测与控制杂志, 2012, 6(10):580-581.

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:

АУ-ы доктор Э.Энхсүрэн